



2017-2018 ОНЫ ШИНЭ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТ БОЛМОО



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн шинэ хичээлийн жилийн нээлт 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр болж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Г.Чулуунбаатар, УИХ гишүүн Б.Саранчимэг, БСШУСЯ-ны Дээд боловсролын газрын дарга Т.Амаржаргалан, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дарга Н.Бэгз, ШУТИС-ийн захирал Б.Очирбат, “Санко” группийн ерөнхийлөгч Шимизү Такаши, Санко маркетинг компанийн захирал Г.Нямдэлгэр, ШУТИС-ийн дэд захирал Х.Энхжаргал, Т.Намнан, Б.Сүхбат, Л.Баяр-Эрдэнэ, ЗХНГ-ын дарга Н.Ганзориг болон бүрэлдэхүүн сургуулийн захирал бусад холбогдох хүмүүс оролцлоо.

Нээлтийн үйл ажиллагааны эхэнд “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-т ШУТИС-ийн тугийг “Парис-2017” чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн ДАШТ-ий эмэгтэйчүүдийн 63 кг жингийн алтан медальт, үндэсний шигшээ багийн тамирчин, Олон улсын хэмжээний мастер, ШУТИС-ийн БУХС-ийн Нийгмийн ажилтны IV дамжааны оюутан П.Орхон, ШУТИС, Механик тээрийн сургуулийн Техникийн механикийн тэнхимийн профессор, доктор (Ph.D) Д.Ганбат нар хүндэтгэлийн тайзан дээр залав.

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-т Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2017-2018 оны хичээлийн шинэ жилийн Нээлтийн ёслолын ажиллагааг нээж Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Захирал, доктор, профессор Б.Очирбат “Эрхэм хүндэт профессор багш нараа, оюутан залуучууд, зочид төлөөлөгчид, эцэг эхчүүдээ та бүхэнд шинэ хичээлийн жилийн баярын мэндийг өргөн дэвшүүлье. Жил бүрийн 9 дүгээр сарын 1 бол манай орны бүх шатны боловсролын байгууллагын

алба ёсны үйл ажиллагаагаа нээдэг ёслолын болон эрдмийн их баярын өдөр байдаг. Энэ уламжлал ёсоор өнөөдөр Шинжлэх ухаан, технологийн их сургууль 2017-2018 оны хичээлийн жилийн үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлж байна.

ШУТИС 2017-2018 оны хичээлийн жилийн хичээл сургалтын үйл ажиллагааны бэлтгэлийг бүрэн хангаж энэ хичээлийн жилд манай их сургуулийн хөтөлбөрүүдийг 4200 гаруй оюутан залуус сонгож ШУТИС-ийн оюутнуудын эгнээг шинээр тэллээ.

Өнгөрсөн хичээлийн жил манай их сургуулийн хувьд өмнөө тавьсан зорилго зорилтуудаа амжилттай хэрэгжүүлсэн олон сайхан баярт үйл явдлаар дүүрэн үр бүтээлтэй жил болж өнгөрсөн. Энэ бүгдээс нэг зүйлийг онцолж хэлэхэд 2016 оны 11 сард манай ШУТИС-ийг аж үйлдвэрийн салбарт хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж 70 мянган инженер технологийн мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргасан түүхэн 55 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор шагнасан. Энэ шагнал манай хамт олны урам зоригийг бадрааж цаашдын ирээдүйд их ажилтанд хүрэх урам зориг хайрласан ийм сайхан баяр үйл явдал байлаа.



ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСЭН ИХ СУРГУУЛЬ БОЛНО

Л.БАЯР-ЭРДЭНЭ: БАГШ АЖИЛЧДЫН 60 ХҮҮХЭД ХҮЛЭЭН АВАХ ЦЭЦЭРЛЭГ БАЙГУУЛНА



МЕХАНИК, ТЭЭВРИЙН СУРГУУЛИЙН 55 ЖИЛИЙН ОЙ ТОХИОЖ БАЙНА

ХБНГУ - КЕМНИЦ ХОТЫН ТИС ЗОЧИН ПРОФЕССОР Т. УРАНЧИМЭГ

ШУТИС-ИЙН “ГЕОДЕЗИ” ХӨТӨЛБӨР ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДЭВ

ШИНЭ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТЭНД



Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал

Х.Энхжаргал

Шинжлэх ухааны доктор, профессор

- ШУТИС-ийн энэ хичээлийн жилийн зорилго, сургалтын бодлогын талаар ямар зорилт тавьж байна вэ?

ШУТИС 2017-2018 оны хичээлийн жилийн хичээл сургалтын үйл ажиллагааны бэлтгэлийг бүрэн хангаж энэ хичээлийн жилд манай их сургуулийн 58 хөтөлбөрт 4200 гаруй бакалавр, 467 магистрант, 54 докторант оюутан шинээр элсэн орсон. Бид шинэ хичээлийн жилийн зорилго зорилтыг Монгол Улсын "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын хүрээнд ШУТИС-ийг Ази тивийн тэргүүлэх их сургуулийн нэгд оруулахаар зорилт тавьж, тодорхой алхмуудыг үе шаттай амжилттай хэрэгжүүлж энэ зорилтдоо хүрэхийн төлөө ажиллаж байгаа. Ийм ч учраас энэ хичээлийн жилийг бид их сургуулиа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх их сургууль болгох эхний алхмыг хийх гарааны жил болгон зарласан. Бид "QS Asia" байгууллагаар Ази тивийн их сургуулиудын үнэлгээ тогтоож рейтинг хийлгэдэг тэр системээр ШУТИС-ийг үнэлүүлэх ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. Мөн манай хөтөлбөрүүдийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх алхмуудыг сүүлийн жилүүдэд амжилттай хэрэгжүүлж байгаа. ЭХС-ийн "Цахилгаан хангамж", ГУУС-ийн "Геодези" хөтөлбөр олон улсын магадлан итгэмжлэлийн Герман улсад төвтэй "ASI-IN", БУХС-ийн "Бизнесийн удирдлага" хөтөлбөр нь олон улсын "ACBSP" байгууллагаар магадлан итгэмжлүүлсэн бөгөөд МХТС-ийн "Цахилгаан холбоо" мэргэжлийн хөтөлбөрийг АНУ-д төвлөрч үйл ажиллагаа явуулдаг АВЕТ байгууллагаар магадлан итгэмжлүүлэх үйл ажиллагаа амжилттай хэрэгжүүлж байна. Цаашид бид 58 хөтөлбөрөө дотоодын болон олон улсын нэр хүндтэй байгууллагаар магадлан итгэмжлүүлэхээр ажиллаж байна. Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд ШУТИС инженерийн боловсролын олон улсын CDIO санаачлагад албан ёсоор нэгдэж бүх түвшний инженерийн боловсролын хөтөлбөрүүдэд чадварлаг инженерүүд бэлтгэх олон улсын шинэ стандартын дагуу хөгжүүлж

ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН ИХ СУРГУУЛЬ БОЛНО

нэвтрүүлэх зорилт тавин, ажиллах юм. Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд АХБ-ны санхүүжилтээр ШУТИС-ийн 3 хөтөлбөрт CDIO стандарт, арга зүй нэвтрүүлэх төсөл 2015-2017 онд хэрэгжиж байгаа.

ШУТИС нь ОХУ, БНХАУ, БНСУ, ХБНГУ, Тайвань, Япон, Энэтхэг зэрэг орны их, дээд сургуулиудтай бакалаврын 18, магистрын 5 хамтарсан хөтөлбөрөөр сургалт зохион байгуулснаар хоёр улсын дипломтой оюутнуудыг төгсгөн гаргаж байна. "Инженер Технологийн Дээд Боловсрол", 1000 инженер Төслийн хүрээд бакалаврын 3 хөтөлбөр, бэлтгэл коосен хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. Мөн дээрхи төслийн хүрээнд ШУТИС-аас магистрын сургалтын хөтөлбөрт 17, докторын сургалтын хөтөлбөрт 15, судлаач оюутан хөтөлбөрт 1, зэргийн бус хөтөлбөрт 112 багш судлаач хамрагдаж, Япон Улсын Коосэн үндэсний технологийн коллежид 56 оюутан шилжин суралцлаа.

- Багшлах боловсон хүчнийг чадваржуулах, тэдний ур чадварыг дээшлүүлэх тал дээр ямар арга хэмжээ авах вэ?

Монгол Улсын БСШУСЯ-наас 2017-2018 оны хичээлийн жилийн зорилгоо "Улсын хөгжил хүнээсээ, хүний хөгжил багшаасаа" гэсэн үзэл баримтлалын хүрээнд "Багшийн хөгжих төлөө" уриагаар хураангуйлан томъёолж байгаа. ШУТИС-ийн хувьд багшийн хөгжлийн талаар улсын болон их сургуулийн хөгжлийн баримт бичиг, мастер төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах, энэ чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах албан ёсны нэгж болох "Багшийн хөгжлийн төв"-ийг байгуулснаас хойш 2 дахь хичээлийн жилээ угтаж байна. Бид орчин үеийн мэдээлэл харилцааны технологид суурилж, олон улсын стандартад нийцүүлэн "Сургалт, чанарын үнэлгээ", "Судалгаа, инноваци", "Олон нийтэд үзүүлэх үйлчилгээ", "Их сургуулийн гүйцэтгэлийн соёл", "Хувь хүний хөгжил, төлөвшил" чиглэлээр гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд тодорхой сургалтуудыг зохион байгуулсан бөгөөд цаашид ч олон ажил төлөвлөөд байна. Энэ хичээлийн жилд бид багшийн хөгжлийг дэмжих, мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхдээ багш нарын мэргэжил дээшлүүлэх хэрэгцээний судалгааг гаргаж, сургалтад хамруулах, багшлах хүний нөөцийг сонгон шалгаруулах, бэлтгэх, мэргэжлийн баримжаа олгох, багшлах эрх олгох, багш дадлагажуулах чиглэлд байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийн үүднээс хандаж, бодитой төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр, ажиллана.

Өнгөрсөн хичээлийн жилд дээд боловсролийн шинэчлэл төслийн хүрээнд

"Үр дүнд суурилсан боловсрол" CDIO-ын стандарт арга зүйн 12 зөвлөмжийн дагуу ШУТИС-ийн профессор багш нарт цуврал сургалт зохион байгуулж, зөвлөмжийн дагуу хөтөлбөрийн сайжруулалт хийгдсэн.

- Оюутанд үзүүлэх үйлчилгээний талаар ямар ажлууд хийгдэж байна вэ?

ШУТИС-ийн Оюутны соёл, үйлчилгээний алба нь оюутанд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг бөгөөд 2017-2018 оны хичээлийн жилд "Оюутны үйлчилгээний хуанли"-ийн дагуу суралцагчдад зориулан хувь хүний хөгжил, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл бичих аргачлал, урлаг спортын уралдаан тэмцээн, оюутны тэтгэлэг олгодог хамтын ажиллагаатай байгууллагуудын өдөрлөг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Манай сургуулийн хувьд оюутны сайн дурын болон мэргэжлийн клубүүдэд суралцагчид сонирхлынхоо дагуу өөрийгөө хөгжүүлэх өргөн боломжтой. Одоогоор ШУТИС-д сайн дурын 17, мэргэжлийн чиглэлийн 19 клуб үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү клубт идэвх санаачилгатай, тогтмол хичээллэдэг, мөн урлаг, спортын арга хэмжээнд сургуулиа төлөөлөн амжилттай оролцдог оюутнуудад зориулан "Кредитийн урамшуулал"-ыг олгодог уламжлал тогтсон. Өнгөрсөн 2016-2017 оны хичээлийн жилд нийт 286 оюутанд 511 кредитийн урамшуулал олгожээ. Мөн оюутнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс Нийслэлийн Хөдөлмөр Эрхлэлтийн газар болон олон нийтийн бусад байгууллагуудтай хамтран байнгын болон цагийн ажлын нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж оюутнуудаа зуучилж ажилладаг ба төгсөгчиддөө зориулж "Ажлын байрны үзэсгэлэн яармаг"-ыг тогтмол зохион байгуулдаг юм. Өдөрлөгт оролцож байгаа байгууллагуудаас ажлын захиалгын дагуу оюутан болон төгсөгчдөө ажилд зуучлаж байна. Манай төгсөгчдийн 70-аас дээш хувь ажлын байраар хангагддаг гэсэн судалгаа бий.

- Оюутан залуус, хамт олондоо хандаж юу хэлэх вэ?

Манай сургуулийг сонгон суралцсан нийт оюутан залуусдаа хичээл сурлагын өндөр амжилт хүсч, монголын ирээдүй та бүхний гарт байгаа шүү, хичээгээрэй л гэж хэлье.

Мянга мянган инженер, технологич, менежерүүдийг төрүүлж эх орондоо өлгийдөн өгч буй эрдэмтэн, профессор багш нартаа ажлын өндөр амжилт, амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсье.

Л.БАЯР-ЭРДЭНЭ: БАГШ АЖИЛЧДЫН 60 ХҮҮХЭД ХҮЛЭЭН АВАХ ЦЭЦЭРЛЭГ БАЙГУУЛНА

Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захиралтай ярилцлаа.

-ШУТИС-д оюутны төлбөрөөс өөр санхүүгийн ямар эх үүсвэрүүд байдаг бэ?

-Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургууль нь төрийн өмчийн их сургууль учраас оюутны төлбөрийн орлогоос гадна улсын төсвийн хөрөнгө оруулалт хийгддэг. Мөн их сургууль гэдэг утгаараа эрдэм шинжилгээ судалгааны ажлын орлого, гэрээт ажлын орлого, хандивлагчдын орлого зэрэг санхүүгийн эх үүсвэрүүдээс бүрдэж байна.

-Энэ жил манай их сургууль гаднын томоохон хөрөнгө оруулалтыг татах талаар ямар бодлого барьж ажиллах вэ?

-Гаднын хөрөнгө оруулалтыг татах талаар бид олон арга хэмжээ авч бодлого боловсруулан ажиллана. Үүнд хамтын ажиллагааны гэрээтэй гадаадын их сургууль, компани, корпорацуудын дэмжлэгийг авахад илүү анхаарч ажиллах болно. Мөн зөвхөн гадаадын хөрөнгө оруулагчдаас гадна дотоодын хамтын ажиллагаатай байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хөрөнгө оруулалтын чиглэлд харилцан ашигтай хамтын ажиллагааг үргэлжлүүлэх төлөвлөгөө гаргаад явж байна.

-Энэ хичээлийн жилд багш нарын нийгмийн асуудалд дэмжлэг болох ямар ажлуудыг хийх вэ?

-Багш ажилчиддаа зориулж эхний ээлжид их сургуулийнхаа дэргэд 60 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай цэцэрлэг байгуулах шийдвэрийг захирлын зөвлөлөөс гаргаж тухайн ажлыг гардан хэрэгжүүлж эхлээд байгаа. Түүнчлэн багш, ажилчдын цалин хөлсийг нэмэх боломжийг судалж, үе шаттай арга хэмжээнүүдийг авахаар төлөвлөсөн. Төлөвлөсөн ажил олон байгаа болохоор цаашид гарах үр дүнг манай хамт олон талархан хүлээж авах байх.

-Цаашид санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх тодорхой ажил юу байгаа вэ?

-Манай Хөрөнгө оруулалт, хангамжийн газар, Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны хамт олон их сургуулийн санхүүгийн үйл ажиллагааны шинэ дүрэм журам, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулах,



Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Л.Баяр-Эрдэнэ

хөрөнгө оруулалтын сангийн журам боловсруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулаад байна. Эдгээр шинэ дүрэм журам, баримт бичигтэй болсноор үргүй зардал багасаж их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаа эрүүлжиж, нээлттэй ил тод байдал нь сайжрах юм.

-Хичээлийн болон оюутны дотуур байр барих ажлыг энэ хичээлийн жилд эхлүүлэх үү?

-Барилга, архитектурын сургуулийн лабораторийн барилга, хичээлийн 8-р байрны барилгын ажлыг эхлүүлнэ. Мөн оюутны 2-р байр, УТС-ийн хичээлийн байр зэрэг барилгуудыг буулгаж шинээр хичээлийн болон оюутны байрууд барих зөвшөөрөл авахаар эрх бүхий төрийн байгууллагуудад хандаад байгаа.

**Баярлалаа,
Танд ажлын амжилт хүсье.**



Механик, тээврийн сургуулийн 55 жилийн ой угтан хийсэн ажлаас

Мэндчилгээ



Механик, тээврийн сургуулийн захирал

Д.Цолмонбаатар

Доктор, дэд профессор

оюутны чөлөөт уншлагын танхим, CDIO сургалтын урлангууд зэргийг шинээр байгуулсан амжилтаар түүхт 55 жилийн ойг угтаж байгаадаа баяртай байна. Бидний санал санаачилгыг үргэлж сайшааж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа гадаад дотоодын байгууллага, сургуулийнхаа нийт хамт олонд ШУТИС-ийн Механик, Тээврийн Сургуулийн 55 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

2016/2017 оны хичээлийн жилд бид сургалт, судалгааныхаа ажлын чанарыг дээшлүүлэх бодлогын хүрээнд хийгдэж байгаа бүхий л үйл ажиллагаагаа төрөлх сургуулийнхаа түүхт 55 жилийн ойд зориулан явуулж ирлээ.

Манай хамт олны сүүлийн жилүүдэд санаачлан хийж хэрэгжүүлж байгаа ажлуудаас онцлон дурдвал, бид Чанарын менежментийн тогтолцооны ISO:9001:2015 стандартыг сургуулийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, амжилттай хэрэгжүүлэн туршиж байна. Энэ ажлын хүрээнд сургуулийн чанарын бодлогыг тодорхойлж, чанарын зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу профессор, багш, ажилтан, ажилчдад зориулсан сургалт семинар зохион байгуулж, чанарын менежментийн тогтолцооны стандартын чиглэлээр мэргэшсэн багш, ажилчдын баг хамт олноо манлайлан ажиллаж байна. Мөн түүнчлэн сургалтын чанарыг дээшлүүлэх зорилтын хүрээнд БСШУСЯ, АХБ-наас хэрэгжүүлж байгаа Дээд боловсролын шинэчлэлийн төслийн санхүүжилтээр Үр дүнд суурилсан, идэвхитэй сургалтын орчин үеийн аргыг "Үйлдвэрлэлийн автоматжуулалт", "Авто инженер", "Машин үйлдвэрлэлийн технологи" хөтөлбөрийн хичээлүүдэд нэвтрүүлэх ажлуудыг амжилттай хэрэгжүүлж байна.

Судалгааны үр дүнг дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр манай профессор багш нар санаачилгатай ажиллаж, Монгол-Японы ЗГ-ын хооронд хэрэгжиж байгаа Инженер технологийн дээд боловсролыг хөгжүүлэх MJEED төслийн хүрээнд Японы их дээд сургуулийн консорциумын сургуулиудтай Механик инженер мэргэжлээр "2+2" хамтарсан бакалаврын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, Японы их дээд сургуулиудтай хамтарсан 3 судалгааны ажлыг эхлүүлээд байна.

Дээрх ажлуудаас гадна манай хамт олон сургуулийнхаа сургалт, судалгааны чанар, орчинг сайжруулах чиглэлээр 10 гаруй төсөл хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж, Инженерийн ахисан түвшний iDesign лаборатори, Цутгуурын лаборатори, оюутны чөлөөт уншлагын танхим, CDIO сургалтын урлангууд зэргийг шинээр байгуулсан амжилтаар түүхт 55 жилийн ойг угтаж байгаадаа баяртай байна. Бидний санал санаачилгыг үргэлж сайшааж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа гадаад дотоодын байгууллага, сургуулийнхаа нийт хамт олонд ШУТИС-ийн Механик, Тээврийн Сургуулийн 55 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Тээврийн салбар

Монгол Улсад Нисэх хүчин үүсэн байгуулагдсан түүхт 92 жилийн ойгоор ИНД 141-р дүрэм "Иргэний нисэхийн сургалтын байгууллага"-аар гэрчилгээжсэнээр тус сургуулийн "Нисэх техникийн механик" мэргэжил олон улсын иргэний нисэхийн байгууллага ИКАО-д хүлээн зөвшөөрөгдөв.



Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах" техникийн туслалцааны төслийн үндэсний зөвлөхөөр ажиллаж байна.



Олон улсын оюутны автомашины тэмцээн

БНСУ-д жил бүр зохиогддог "INTERNATIONAL STUDENT CAR COMPETITION" тэмцээнд МехТС-ийн оюутнууд өөрсдийн зохион бүтээсэн цахилгаан автомашинаараа 5 дахь жилдээ амжилттай оролцож байна. Энэ жил 150 метрийн хурд авалт төрөлд 10 секундын хугацаа зарцуулж 7-р байр, уран жолоодлогын төрөлд 28 секундын хугацаа зарцуулж 9-р байр, 45 км-ын холын зайн уралдаанд 20 байр үзүүлсэн амжилттай оролцлоо.

Машины үйлдвэрлэлийн салбар

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Метал хайлах лаборатори, Цутгуурын лаборатори гэсэн 2 лабораторид тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн.

"Инженер Технологийн Дээд Боловсрол" Төсөл



ХБНГУ-ын АМАТЕК компанид үйлдвэрлэсэн металын химийн шинжилгээ хийдэг спектрометр SPECTROMAXx M маркийн багаж



Хар болон өнгөт метал хайлах зуух, хонх цутгах, төвөөс зугатах, элс шавран хэвний цутгуурын сургалтын 3 ком багаж

Шинэ материалын дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлт төслийн ерөнхий координатор профессор М.Дэлгэрмаа Төслийн хүрээнд 3 үндсэн чиглэлээр судалгаа хийж ажиллаж байна. Үүнд:

1. Вольфрамын карбид суурьтай хатуу хайлш нунтаг металлургийн аргаар үйлдвэрлэх технологийн судалгаа
2. Полимер материалын технологийн судалгаа
3. Монгол орны нарс модны физик механик шинж чанарын судалгаа гэсэн чиглэлүүдэд судалгаа хийдэг.

Механик, мехатроникийн салбарын ажил



Үйлдвэрлэлийн механикжуулалтын мэргэжлийн оюутнуудын үйлдвэрлэлийн дадлагаар сургуулийн 55 жилийн ойд зориулан нэмэлт авто зогсоолыг сайжруулан засварлах ажил гүйцэтгэв. Удирдагч багш: Х.Чулуунбаатар



CDIO, Үйлдвэрлэлийн автоматжуулалт хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудад зориулан Дээд боловсролын шинэчлэлийн төслийн шугамаар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2 урлан ашиглалтанд оруулсан.

Техникийн механикийн тэнхим



“Монгол инженер 2017” нэгдсэн арга хэмжээ

Сургуулийн 55 жилийн ой угтсан ажлын хүрээнд “Монгол инженер 2017” нэгдсэн арга хэмжээг 2017 оны 4-р дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 13 албан байгууллагын инженер, техникийн ажилтнууд, дотоодын 8 их, дээд сургуулийн 148 оюутан, 70 гаруй профессор багш ажилтнууд оролцлоо.



iDesign лаборатори

ШУТИС-МехТС-ийн 55 жилийн ойн хүрээнд 6,7 сая төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалтаар тохижуулан iDesign (Intelligent Design) нэртэйгээр CAD/CAE/IoT/IT болон инженерийн програм хангамжийн хөгжүүлэлт чиглэлээр сургалт, судалгааны ажил явуулж байна.

Ой угтсан оюутны бүтээлээс



Тэргүүн байр

CNC Машин
Удирдагч: Э.Наранбаатар
Гүйцэтгэгч: Ц.Доржсүрэн

Дэд байр

Цаг уур орчны шинжилгээ хийх хөдөлгөөнт төхөөрөмж.
Удирдагч: Б.Дондогжамц
Гүйцэтгэгч: Ш.Баасанхүү

Гутгаар байр

Цас цэвэрлэгч төхөөрөмж
Удирдагч: Х.Чулуунбаатар
Гүйцэтгэгч: Ч.Билэгсайхан



Шинжлэх ухааны доктор, профессор
Олон Чүлтэм овогт Түдэвдагвын
УРАНЧИМЭГ

Товч намтар:

Төрсөн огноо: 1969 оны 9-р сарын 11
Төрсөн газар: Улаанбаатар хот

Боловсрол, цол:

- Бүрэн дунд боловсрол: 72-р сургууль, 1987 он
- Бакалавр: ЗСБНХУ, Новосибирск хот, ЦДТС, 1992 он
- Магистр: Монгол улс, УБ хот, ТИС, 1997 он
- Техникийн Ухааны Доктор (PhD): ОХУ, Новосибирск хот, УТИС, 2003
- Дэд профессор цол: Монгол улс, УБ хот, ШУТИС 2008 он
- Шинжлэх ухаан доктор (ScD, Dr.-Ing. Hab.): ХБНГУ, Кемниц хот, ТИС, 2014 он
- МУ-н Зөвлөх Инженер: Монгол улс, УБ хот, 2015 он
- Хүндэт Доктор: ОХУ, Новосибирск хот, УТИС, 2017

Шагналууд:

- ЭХИС-ийн болоод ШУТИС-ийн Шилдэг багш, Топ профессор: 2008, 2010, 2015
- Шлюмбержер сангийн шилдэг эмэгтэй эрдэмтэдэд олгодог Грант: 2011-12
- БСШУЯамны Хүндэт Жуух бичиг
- ЭХ-ний Тэргүүний ажилтан

Гишүүнчлэл:

- ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн
- ЭХС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн
- ШУТИС-ийн Ном сурах бичгийн дэд зөвлөлийн гишүүн
- Олон улсын IEEE байгууллагын гишүүн
- Faculty for the future нийгэмлэгийн гишүүн
- Schlumberger сангийн Элч төлөөлөгч
- НЭТИ-НГТУ төгсөгчдийн холбооны гишүүн
- Монголын Эмэгтэй Эрдэмтэдийн Холбооны Удирдах Зөвлөлийн гишүүн
- “Насан туршийн суралцагч” ТББ-ийн Удирдах Зөвлөлийн гишүүн

ХБНГУ - КЕМНИЦ ХОТЫН ТИС ЗОЧИН ПРОФЕССОР Т. УРАНЧИМЭГ

Судалгааны ажлын замнал түүх
ПДС их сургууль болон өргөжсөний дараагаар цолтой багш нарын тоог нэмэгдүүлэх зорилготой олон ажлуудыг тухайн үед Ректор байсан Профессор багш Д.Бадарч санаачлан хийж байсны нэг нь “Зорилтот аспирантур” сургалт байсан юм. Т.Уранчимэг энэ сургалтанд 1998 онд хамрагдаж 2001 онд төгсжээ. Улмаар эрдмийн ажлаа дуусган хамгаалахаар төрөлх сургууль Новосибирск хот руу хөлгийн жолоо залжээ.

Зорьсон ажлаа амжилттай дуусгаж, Техникийн ухаан докторын зэргийг “Ойртон дөхөх оновчлолын аргаар хүн-машины системийг автоматжуулах” сэдвээр 2003 онд хамгаалжээ. Эрдэм судлалын ажлаа үргэлжлүүлэн КТ-г сургалтанд хэрхэн үр дүнтэй ашиглах, оновчтой шийдлийн талаар судалгааны ажлуудыг хийжээ.

2007 оноос эхлэн цахим сургалтын чиглэлээр ажиллаж эхэлсэн нь дараагийн эрдмийн ажлын санаа гарах суурь болж өгчээ. Бодитоор байгуулахад өвөр хэмжээ ихтэй, өртөг өндөртэй лабораториудыг цахим хэлбэрээр байгуулан сургалтанд ашиглах, цахим сургалтын чанарын үнэлгээний асуудлаар хийх судалгааны ажлын санаа нь шалгарч, 2011 онд олон улсын Шлюмбержер сан Докторын дараах судалгаа хийх 40 000 долларын шагналыг хүлээн авсан энэхүү нэр хүндтэй Тэтгэлэгийг хүлээн авсан анхны эмэгтэй багш, судлаач болсон юм. Энэхүү тэтгэлэгийн хүрээнд судалгааны ажлаа дуусгаж хамгаалахаар ХБНГУ-н Кемниц хотын ТИС-ийг зорьжээ.

Судалгааны ажлаа амжилттай дуусгаж, “Цахим сургалтанд зориулсан бүтэц дээр суурилсан үнэлгээний загвар” сэдвээр ШУ-ны Докторын зэргийг 2014 онд хамгаалсан нь компьютерийн шинжлэх ухааны салбарт анхны, эмэгтэй ШУ-ны Доктор цолыг хүртсэн амжилтыг үзүүлсэн юм.

Одоо тэрээр цахим сургалтаас гадна орчин үеийн дэвшилтэт технологиудыг хэрхэн инженерийн шийдлүүдэд ашиглах чиглэлээр анхааран ажиллаж байна. Одоо тэрээр, цахилгаан дамжуулах агаарын шугамын дээд үзлэгийг нисгэгчгүй нисэгч төхөөрөмжөөр хянаж, гэмтэл согогийг дүрс боловсруулалтын аргаар илрүүлэх автомат системийг хийж, хэрэгжүүлэхээр Герман-Монголын судлаач нартай хамтран ажиллаж байна.

Судалгааны ажлын онцлог, ач холбогдол ба Олон улсын хамтын үйл ажиллагаа

Албан болоод албан бус боловсролын, мөн ахьсан шатны боловсролын ирээдүйн

үндсэн хэлбэр нь ЦАХИМ СУРГАЛТ юм. Цахим хэлбэрээр суралцах нь насан турш суралцах боломжийг хүн бүрт тэгш олгодог ороо маш давуу талтай сургалтын хэлбэр болох нь улам бүр батлагдаж байна. Цахим сургалт нь өөрөө шинэ дутам хөгжиж байгаа залуу салбар учир ийм хэлбэрийн сургалтын чанарыг үнэлэх олон улсын хэмжээний тогтсон стандарт арга аргачлал хараахан бий болоогүй байна. Цахим сургалтын үнэлгээг төлөвлөлтөөс нь эхлүүлээд өгөгдөл боловсруулж үр дүнг тайлагнах хүртэл бүх алхамуудыг багтаасан үнэлгээний иж бүрэн системийг боловсруулж, дэлхийн судлаач нарт хүргэснээрээ Т.Уранчимэгийн докторын ажлын онцлог оршино. АНУ-н болоод Канадын эрдэмтэн судлаач нар түүний аргачлалыг шинэ болоод цаашдаа олон салбарт ашиглах боломжтой аргачлал болсныг хүлээн зөвшөөрч хамтран ажиллаж эхлээд байна. Энэ нь ШУТИС-н профессор багш нар, Монгол улсын эрдэмэн судлаач нар дэлхийн хэмжээнд зүй ёсоор үнэлэгдэж байгааг батлан харуулсан нэгэн жишээ юм.

Тэрээр зөвхөн өөрөө сурч боловсорч урагшлаад зогсохгүй олон залуу багш, судлаач нарыг ажлын байран дээрээ хөгжиж, эрдэм судлалын ажлаа амьдралтайгаа хослуулан ахиц үлгэр дуурайлалыг өөрийн биеэр харуулан, энэ чиглэлээр багагүй ажлуудыг төгссөн Орос болоод Герман сургуулиудтайгаа хамтран хийж байна. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд 2010 оноос эхлэн жил бүр зуны сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийтдээ 150 гаран судлаачид, оюутан нарыг хамруулаад байна. 2015 онд ХБНГУ-н Кемниц хотын ТИС, ЭХС-д 35 000 евроны өртөгтэй 2 төрлийн лабораторийг хандивлах үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлсэн. ОХУ-н Новосибирск хотын УТИС-тай хамтарсан семинарыг 2015-оос эхлүүлж судлаач нарын бүтээлийг хэлэлцүүлэн, чансаа өндөртэй олон улсын сэтгүүлд хэвлүүлэхэд анхааран ажиллаж байна. ХБНГУ-н Кемниц хотын ТИС-д магистрт 1 оюутан, докторын сургалтанд 2 залуу багшийг татан авч сургажээ. Энэхүү хичээл зүтгэлийг нь өндрөөр үнэлж, ОХУ-н Новосибирск хотын УТИС түүнд “Хүндэт Доктор”-ийн зэргийг 2017 оны 4-р сард хүртээсэн нь манай сургуулийн багш нар олон улсын их дээд сургуулиудад өндрөөр үнэлэгдэж байгааг дахин батлан харуулсан сайхан үйл явдал болоод байна.

2016 оны 11-р сараас эхлэн Т.Уранчимэг ХБНГУ-н Кемниц хотын ТИС-д уригдан ажиллаж байгаа хэдий ч бүх сэтгэл зүрхээрээ төрөлх сургууль ШУТИС, эрдмийн хамт олонтойгоо байнгын нягт холбоотой ажиллаж, хувь нэмрээ оруулсаар байна.



ШУТИС-ийн “Геодези” хөтөлбөр олон улсад магадлан итгэмжлэгдэв



2017 онд ХБНГУ–ын Инженер, мэдээлэл зүй, байгалийн ухаан, математикийн мэргэжлийн хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлэх агентлаг /ASIIN e.V./-аар Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн “Геодези”-ийн хөтөлбөр магадлан итгэмжлэгдлээ. ШУТИС-ийн Геодези хөтөлбөрийн хамт олонд 2017 оны 9 сарын 06-ны өдөр БСШУС-ын сайд бөгөөд БМИҮЗ (Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл)-ийн дарга Г.Чулуунбаатар олон улсад магадлан итгэмжлэгдсэн батламжийг гардуулав.

Олон улсын түвшинд магадлан итгэмжлэгдсэнээр “Геодези” хөтөлбөрөөр төгсөгчдийн боловсролын баримт бичгүүд олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, төгсөгчид маань олон улсад магадлан итгэмжлэгдсэн их сургуулиудад ахисан түвшинд үргэлжлүүлэн суралцах, эзэмшсэн мэргэжлээрээ гадаад улс оронд ажиллах боломж нээгдэж байгаа.

1980 оноос ШУТИС нь “Геодези” мэргэжлээр дээд боловсролтой

мэргэжилтэн бэлтгэж эхэлсэнээс хойш 2012 онд дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын үнэлгээгээр геодези мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг үнэлүүлж Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэгдэн гэрчилгээ авсан.

Манай хамт олон сургалтын үйл ажиллагаагаа гадаад улс орны сургалтын үйл ажиллагаатай нийцүүлэх, тэдгээр байгууллагуудтай харилцан итгэлцэх, улс улсын сургалтын хөтөлбөрүүдийг хүлээн зөвшөөрөх ажлын хүрээнд 2013 оноос олон улсад магадлан итгэмжлүүлэх ажлыг эхлүүлсэн. 2017 оны 9 сард Герман улсын Олон улсын дээд боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллага нь “Геодези” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг магадлан итгэмжлэхээр ASIIN байгууллагаас доктор, профессор шинжээчдээс бүрдсэн магадлан итгэмжлэх баг ШУТИС-д ажилласан. Шинжээчдийн баг “Геодези” мэргэжлээр бакалавр зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн сургалтыг хэрэгжүүлж буй багш, профессорууд, сургалтын албаны ажилтнууд, суралцаж буй оюутан залуучуудтай биечлэн уулзаж, сургалтын бүхий л үйл ажиллагаатай нарийвчлан танилцаж, сургалтын орчин, анги танхим, номын сан, эрдэм шинжилгээ, сургалтын зориулалттай лабораториудыг үзэж сонирхсон. Шинжээчдийн багийн гишүүд ШУТИС-д ажиллаж, сургалтын үйл ажиллагаатай бүрэн танилцаж судалсаны үндсэнд “Геодези” мэргэжлээр бакалавр зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлж буй хамт олны хөдөлмөр, ажлын үр дүнг өндрөөр үнэлж манай хамт олонд магадлан итгэмжлэлийн гэрчилгээг олгосон.



ШИНЭ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТЭНД



Ч.Мангалжалав захиралтай Эрчим хүчний сургуулийн хамт олныг 2016-2017 оны хичээлийн жилд дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх, их сургуулийн сургалт, судалгааны орчин, материаллаг баазыг бэхжүүлэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, судалгааны ажлыг хөгжүүлэх чиглэлд гүйцэтгэсэн үйл ажиллагааны үр дүнгээр ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудыг манлайлан, амжилт гарган ажилласныг тань өндрөөр үнэлж ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл, Захирлын зөвлөлөөс өргөмжлөл, болор цомоор шагнасныг ШУТИС-ийн захирал Б.Очирбат гардуулав.

Мөн энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор БАС-ийн профессор П.Отгонбаяр, “Алтан гадас” одонгоор ГХИ-ийн профессор С.Дугармаа, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар ГУУС-ийн ахлах багш С.Сийлэгмаа нар шагнагдаж нээлтийн ажиллагаанд оролцож буй хүндтэй зочид гардуулан өглөө.

Жил бүрийн шинэ хичээлийн жилийн нээлтийн ажиллагааны үеэр шилдэг элсэгчдээ ШУТИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг мөн хамтран ажилладаг байгууллагын нэрэмжит тэтгэлгийг оюутнууддаа гардуулдаг уламжлалтай. 2017-2018 оны хичээлийн жилд ШУТИС-д шинээр элссэн шилдэг элсэгч болох А.Баяржаргал, Ч.Ганцэцэг, Ц.Намсрайдорж, Э.Анхбаяр, З.Итгэлбаяр, А.Отгонбаяр, Б.Энхжаргал, Б.Золбаяр, Э.Ариунболд, Д.Тулгабат, Н.Номинд “ШУТИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэг” гардуулав. “Санко групп”-ийн нэрэмжит тэтгэлгийг М.Энхжин, Б.Бямбасүрэн, Ц.Хулан, Б.Буяндэлгэр, С.Ариунсүлд нарын 5 оюутан авлаа.

